

ГАРЧИГ

| | |
|--|-----------|
| БҮЛЭГ 1. ОРШИЛ | 4 |
| БҮЛЭГ 2. ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА | 5 |
| БҮЛЭГ 3.ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА | 6 |
| 3.1.Төлөвлөгөөний нэр..... | 6 |
| 3.2.Төсөл хэрэгжүүлэгч байгууллага..... | 6 |
| 3.3.Төслийн зорилго | 6 |
| 3.4.Төсөл хэрэгжүүлэгчийн танилцуулга | 6 |
| 3.5.Төслийн байршил..... | 6 |
| 3.6.Орд ашиглах тусгай зөвшөөрөл..... | 7 |
| 3.7.Ил уурхайн ашиглалтын технологи..... | 8 |
| 3.8. Ил уурхайн хэмжээ, хэмжээсүүд | 8 |
| 3.9.Төслийн хүчин чадал, ажиллах горим | 8 |
| 3.10.Тоног төхөөрөмжүүд..... | 9 |
| БҮЛЭГ 4. ТӨСЛИЙН ГОЛ БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ | 10 |
| 4.1.Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт..... | 10 |
| БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ | 12 |
| 5.1.Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт..... | 12 |
| 5.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт | 17 |
| 5.3.Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт | 19 |
| 5.4.Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт | 22 |
| 5.5.Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт | 22 |
| 5.6.Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт | 22 |
| 5.7.Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт | 27 |
| 5.8.Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт..... | 30 |
| 5.9.Тухайн жилийн БОМТ-ийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт..... | 33 |
| 5.10.Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт | 39 |
| 5.11.Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлангийн нийт зардал..... | 40 |
| ДҮГНЭЛТ | 41 |

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ.....42

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

| | |
|---|----|
| Хүснэгт 1. Товч мэдээлэл / “Сүхжин” ХХК / | 6 |
| Хүснэгт 2. Уурхайн солбилцол..... | 6 |
| Хүснэгт 3. Ил уурхайн зохиомжлолд тусгасан үзүүлэлтийн хэмжээс..... | 8 |
| Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт..... | 12 |
| Хүснэгт 5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт..... | 15 |
| Хүснэгт 6. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт..... | 17 |
| Хүснэгт 7. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт..... | 17 |
| Хүснэгт 8. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт..... | 19 |
| Хүснэгт 9. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт..... | 22 |
| Хүснэгт 10. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт..... | 27 |
| Хүснэгт 11. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт..... | 30 |
| Хүснэгт 12. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт..... | 33 |
| Хүснэгт 13. БОМТ-ийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарийн биелэлт..... | 39 |
| Хүснэгт 14. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлангийн нийт зардал..... | 40 |

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

| | |
|--|----|
| Зураг 1. Тусгай зөвшөөрөлтэй талбайн байр зүйн зураг..... | 7 |
| Зураг 2. Уурхайд усалгаа хийгдэж байгаа байдал..... | 13 |
| Зураг 3. Тээврийн хэрэгслийг техникийн үзлэгт хамруулсан баримт..... | 13 |
| Зураг 4. Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлын төлбөр төлсөн баримт..... | 14 |
| Зураг 5. Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлын төлбөр төлсөн баримт..... | 14 |
| Зураг 6. Уурхайн үйл ажиллагаа явагдаж байгааг анхааруулсан тэмдэг тэмдэглэгээ байршуулсан байдал..... | 16 |
| Зураг 7. Замын тэмдэг тэмдэглэгээ байршуулсан байдал..... | 16 |
| Зураг 8. Шимт хөрс болон хаягдал овоолгыг ашиглан нөхөн сэргээлт хийсэн байдал..... | 18 |

| | |
|---|----|
| Зураг 9. Хиймэл нуурын эргэн тойронд хөрс асгаж, хөрсийг тэгшилж тохижуулсан байдал..... | 18 |
| Зураг 10. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ хийгдсэн газар | 20 |
| Зураг 11. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээндий хүрээнд газрыг булж техникийн нөхөн сэргээлт хийсэн байдал..... | 20 |
| Зураг 12. Мод бут тарьсан байдал | 21 |
| Зураг 13. Модны усалгаа хийгдэж байгаа байдал..... | 21 |
| Зураг 14. 2024 оны аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө | 24 |
| Зураг 15. Гал унтраах багаж хэрэгслийг сайжруулсан байгаа нь..... | 24 |
| Зураг 16. Үерээс хамгаалах далан шуудууг зассан байдал | 25 |
| Зураг 17. Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцсаар хангасан байдал | 25 |
| Зураг 18. Ажилчдад аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч байгаа байдал | 26 |
| Зураг 19. Ажилчдад аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч байгаа байдлын тэмдэглэл | 26 |
| Зураг 20. Шатах тослох материалыг хуримтлуулсан сав..... | 28 |
| Зураг 21. ШТМ болон аюултай хог хаягдлыг хадгалах талбайг хатуу хучилттай болгосон байдал | 28 |
| Зураг 22. Хог тээвэрлэлтийн гэрээ | 29 |
| Зураг 23. Агаарын шинжилгээний дүн | 31 |
| Зураг 24. Хөрсний шинжилгээний хариу..... | 32 |
| Зураг 25. Усны шинжилгээний хариу | 32 |
| Зураг 26. Улаан Загалмай хорооноос ажилчдад анхан шатны сургалт зохион байгуулсан байдал | 35 |
| Зураг 27. Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан байдал | 36 |
| Зураг 28. Цасыг цэвэрлэж цасанд дарагдсан айлуудыг гаргаж өгсөн байдал | 36 |
| Зураг 29. Цасыг цэвэрлэж цасанд дарагдсан айлуудыг гаргаж өгсөн байдал | 37 |
| Зураг 30. Үхсэн малын сэг зэмийг цэвэрлэж байгаа байдал | 37 |
| Зураг 31. Байгаль орчны аудит хийлгэсэн байдал | 38 |

БҮЛЭГ 1. ОРШИЛ

“Сүхжин” ХХК –ийн элс-хайрганы холимгийн ордын байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг боловсруулахдаа байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дүгээр сарын 29 –ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан аргачлалыг баримталсан бөгөөд БОМТ –нд багтах нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох зэрэг арга хэмжээний төлөвлөгөө, нөхөн сэргээлт зэрэг ажлууд хийгдэхгүй болно.

“Сүхжин” ХХК-ийн 2024 оны байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө (БОХТ) нь уг төслийн үйл ажиллагааг эрхлэн явуулах бүхий л үе шатыг хамрах ба гол зорилго нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, багасгах, төсөл хэрэгжиж бүхий нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалахтай холбогдсон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршино.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгаснаар төслийн үйл ажиллагаа болон түүний хүрээлэн буй нутаг дэвсгэр дэх бүх сөрөг өөрчлөлтүүдэд үнэлгээ хийх хэрэгтэй. Мөн түүнчлэн байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн ажлын үр дүнгүүдэд үнэлгээ хийх шаардлагатай. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалах ажил хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан.

Тус төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг боловсруулахдаа байгаль орчин, ногоон хөгжлийн яамны сайдын 2019 оны 10 дүгээр сарын 29 –ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан аргачлалын дагуу энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын талаар авах арга хэмжээ, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан бөгөөд төсөл хэрэгжүүлэгч нь жил бүрийн 11 дүгээр сарын 01-ны дотор тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төслийн хамт холбогдох байууллагад хүргүүлж байх зайлшгүй шаардлагатай болно.

“Чойбалсан-1” элс-хайрганы холимгийн ордын БОМТ-ний биелэлтийн тайланд 2024 онд нийт **55,055,700** төгрөг зарцууллаа.

БҮЛЭГ 2. ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө нь тухайн төслөөс байгаль орчинд учруулах гол сөрөг нөлөөлөл болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг тодорхойлж түүнд шаардагдах хөрөнгө зардлыг тусгадаг.

“Сүхжин” ХХК нь тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 11-р сарын 01-ны дотор төсөл хэрэгжүүлж байгаа аймаг, нийслэлийн байгаль орчны газарт хүргүүлж байх шаардлагатай.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг БОАЖСайдын 2019 оны 10 сарын 29-ны өдрийн “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулж, холбогдох материалуудыг хавсаргалаа.

Тухайн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн товч танилцуулга

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний ажлын гол зорилго нь “Чойбалсан-1” элс хайрганы холимгийн ордын үйл ажиллагааны бүхий л үе шатыг хамрах ба төслийн үйл ажиллагаанас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг болзошгүй гол нөлөөлөл болон цаашид учруулж болзошгүй эерэг болон сөрөг нөлөөллийг бууруулах, багасгах, төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчныг хамгаалахтай холбогдсон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршино.

“Сүхжин” ХХК нь нь 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу сөрөг нөлөөллийг бууруулах ажлууд болох тоосжилт үүсэх үед уурхайн замд усалгаа хийх, өнгөн хөрсний овоолго байдлаар хадгалах, тээврийн хэрэгслийг тогтмол нэг замын маршрутаар явуулах, замын тэмдэг тэмдэглэгээ байршуулах, дүйцүүлэн хамгаалах ажил, хог тээвэрлэлтийн гэрээ, орон нутагтай хамтарч ажиллах, хөрс, усны шинжилгээ хийх, галаас хамгаалах багаж хэрэгслийг байршуулах, хөдөлмөр хамгааллын сургалт, ажилчдыг хувцсаар хангах, ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах зэрэг 2024 онд төлөвлөгдсөн ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

БҮЛЭГ 3.ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

3.1.Төлөвлөгөөний нэр

“Чойбалсан-1” элс-хайрганы холимгийн ордын 2023 оны байгаль орчны менежментийн
төлөвлөгөөний биелэлт

3.2.Төсөл хэрэгжүүлэгч байгууллага

“Сүхжин” ХХК

3.3.Төслийн зорилго

“Чойбалсан-1” ордын элс-хайрганы холимгийг олборлож зах зээлд нийлүүлж борлуулахад
чиглэнэ.

3.4.Төсөл хэрэгжүүлэгчийн танилцуулга

Хүснэгт 1. Товч мэдээлэл / “Сүхжин” ХХК /

| № | Үзүүлэлтүүд | | |
|----|--------------------------------------|----------------------|--|
| 1 | Аж ахуйн нэгжийн нэр | “Сүхжин” ХХК | |
| 2 | Улсын бүртгэлийн дугаар | 0711001032 | |
| 3 | Уурхайн нэр | “Чойбалсан-1” | |
| 4 | Ордын нэр | “Чойбалсан-1” | |
| 5 | Ордын байршил | Нийслэл/Хот/ Аймаг | Дорнод |
| 6 | | Сум/Дүүрэг | Хэрлэн |
| 7 | Ашигт малтмалын төрөл | Элс-хайрганы холимог | |
| 8 | Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар | ДО-001А | |
| 9 | Ашиглалт эхэлсэн огноо | - | |
| 10 | Аж ахуйн нэгжийн хаяг | Аймаг/Хот | Дорнод |
| 11 | | Сум/Дүүрэг | Хэрлэн |
| 12 | | Баг/Хороо | 6-р баг |
| 13 | | Гудамж/Байр | 1-тоот |
| 14 | | Утас | 976-70582092 |
| 15 | | Гар утас | 976-99529549 |
| 16 | | Электрон шуудан | Suhjin.goltd@gmail.com |
| 17 | | Захирлын хаяг | Нэр |
| 18 | Гар утас | | 99992068 |


3.5.Төслийн байршил

“Чойбалсан-1” элс-хайрганы орд нь Дорнод аймгийн Хэрлэн сумын 5-р багийн нутагт
харьяалагдах бөгөөд аймгийн төвөөс 2.5 км зайд оршино (1-р зураг).

Ашиглалтын тусгай зөвшөөрлөөр эзэмшиж буй талбайн захын цэгүүдийн солбицол:

Хүснэгт 2. Уурхайн солбицол

| № | Уртраг | Өргөрөг |
|----|-----------------|----------------|
| 1. | 114° 33' 02,00" | 48° 02' 03,00" |
| 2. | 114° 33' 02,00" | 48° 02' 36,00" |
| 3. | 114° 33' 30,00" | 48° 02' 36,00" |
| 4. | 114° 33' 30,00" | 48° 02' 03,00" |



Зураг 1. Тусгай зөвшөөрөлтэй талбайн байр зүйн зураг

3.6.Орд ашиглах тусгай зөвшөөрөл

Дорнод аймгийн Хэрлэн сумын нутагт орших “Чойбалсан-1” нэртэй 59.2 га талбай бүхий ашигт малтмалын ДО-001А дугаартай тусгай зөвшөөрлийг 2018 оны 03 дугаар сарын 12-ны өдөр “Сүхжин” ХХК-д олгосон байна.

3.7.Төслийн үйлдвэрлэлийн нөөц

“Чойбалсан-1” элс-хайрганы холимгийн ордын нөөц нь Уул уурхайн сайдын 2015 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 203 тушаалын хавсралтын дагуу I бүлгийн орд бөгөөд хайгуулын ажлаар тогтоогдсон геологийн бодитой (В) нөөцөд тулгуурлан ордыг ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийг боловсруулсан байна.

Уурхайн хил хязгаар дотор орших хаягдал, бохирдол тооцсон эдийн засгийн хувьд үр ашигтай нөөцийг тооцохдоо Геологийн бодитой (В) зэрэглэлийн нөөцийг магадласан (В') үйлдвэрлэлийн нөөцөд шилжүүлэн тооцоолов. Ордын магадласан (В') үйлдвэрлэлийн нөөцөөр 2,137.43 мян.м³ элс-хайрганы холимог олборлоно. Нийт 265.32 мян.м³ хөрс хуулах ба хөрс хуулалтын дундаж коэффициент 0.12 м³/м³ байна.

3.7. Ил уурхайн ашиглалтын технологи

Уул-техникийн нөхцөл: Орд газар нь Чойбалсан хотын төвөөс чанх урагшаа Хэрлэн голын хөндийд 1-р дэнжийн тохойрсон хаяа хэсгээр оршдог. Хайгуулын ажлын малталтаар 23 малталтанд хөрсний 4.3-4.5 метрт ус илэрсэн. Ордын геологийн тогтоц нь энгийн тогтоцтой орд юм. Хөрсний дундаж зузаан 0.5 м, элс-хайрганы дундаж зузаан 4.93 м байна. Ордын элс-хайрганы холимгийн болон хөрсний зузаан, блокийн урт, өргөн зэрэг үндсэн үзүүлэлтүүд нь харьцангуй жигд тогтвортой үргэлжилдэг уурхайн олборлолт, ашиглалтын явцад ямар нэг хүндрэл байхгүй үйлдвэрлэлийн жигд ажиллагааг хангах сайн талтай.

Уурхайн нээлт: “Чойбалсан-1” элс-хайрганы холимгийн ордын нээлтийг ерөнхий траншейгаар В-3 блокоос уулын ажлыг эхлэн явуулна.

Ашиглалтын систем: Ордыг ил аргаар гадаад, дотоод овоолго бүхий авто тээвэртэй ашиглалтын системээр ашиглаар ашиглахаар сонгов.

3.8. Ил уурхайн хэмжээ, хэмжээсүүд

Уурхайн хэмжээ: Уурхайн оновчтой хүрээ, хязгаарыг тооцож нөөцийг бүрэн дүүрэн ашиглахад магадласан (В') үйлдвэрлэлийн нөөцийн дагуу 2,137.43 мян.м³ элс-хайрганы холимог олборлохоор байна.

Мөн В-3 нөөцийн зарим хэсэг уурхайн доголыг үүсгэхэд лицензийн хүрээнд тулж байгаа учраас уурхайн гадна хаягдах нөөцийн хэмжээ 0.18 мян.м³ байна.

Уурхайн эцсийн байдлаар ашиглаж дуусахад дунджаар 790м х 540м харьцаа бүхий ухаш үүснэ.

Ил уурхайн хэмжээсүүд: Ил аргаар олборлох ашиглалтын хувилбарыг сонгож ил уурхайн үндсэн хэмжээсүүдийг сонголоо.

Хүснэгт 3. Ил уурхайн зохиомжлолд тусгасан үзүүлэлтийн хэмжээс

| № | Үзүүлэлт | Хэмжих нэгж | Хэмжээс |
|---|------------------------------------|-------------|---------|
| 1 | Ил уурхайн ажлын доголын өндөр | м | 2.7 |
| 2 | Ил уурхайн ажлын бус доголын өндөр | м | 5.5 |
| 3 | Доголын хажуугийн өнцөг | град | 65 |
| 4 | Траншейн өргөн | м | 10 |
| 5 | Траншейн налуу | % | 80 |

3.9. Төслийн хүчин чадал, ажиллах горим

“Чойбалсан-1” элс-хайрганы холимгийн ордын ил уурхайн хүчин чадлыг захиалагч компанийн саналыг үндэслэн хүчин чадлыг жилд 26.0 мян.м³ элс-хайрганы холимог олборлохоор техник-эдийн засгийн үндэслэлд тусгасан байна.

“Чойбалсан-1” элс хайрганы холимгийн уурхайгаас 2023 онд 26.0 мян.м³ элс хайрганы холимог олборлон борлуулна.

Уурхай нь 04 дүгээр сарын 15-наас 09 дүгээр сарын 15-ны хооронд тасралтгүй ажиллах бөгөөд 1 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 8 цаг байна. 2022 онд нийт 126 хоног ажиллана.

3.10.Тоног төхөөрөмжүүд

Ил уурхайд хөрс хуулалт болон элс-хайрганы холимог олборлолтын ажлуудад ухаж ачих, тээвэрлэх ажлыг хийж гүйцэтгэнэ. Догол дээр экскаватор ажиллаж, олборлолтын ажлыг хийж гүйцэтгэнэ.

Техникийн даалгаварт тусгагдсан уурхайн үндсэн тоног төхөөрөмжүүдэд CAT 320C маркийн экскаватор 1 ширхэг, 25 тн даацтай Northbenz ND3250 автосамосвал 2 ширхэг, XCMG-XC955III утгуурт ачигч 1 ширхэг байна.

БҮЛЭГ 4. ТӨСЛИЙН ГОЛ БОЛЗОШГУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

4.1. Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

Газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөлөл: Уурхайн хөрс хуулалт, ачилт, тээвэрлэлт зэргээс ихээхэн хоосон орон зай үүсэх бөгөөд хөрсөн бүрхэвч, ургамал болон шавжнуудын амьдрах орчинг өөрчилж ховор болон эндемик/унаган/ төрөл зүйлийг багасгах магадлалтай. Үйл ажиллагааны турш тээвэрлэлт явагдах тул талбайн ойр орчмын газрын гадаргыг тоос дарж хөрс, ургамал, орчныг бохирдуулна.

Хогийн цэгээс үүсч болзошгүй сөрөг нөлөөлөл: Хогийн цэг байгуулах талбайд төслийн хугацааны явцад засвар үйлчилгээний төв болон ажилчдын тосгоноос гарсан хог хаягдал үүссэнээр газрын гадаргад бохирдол үүснэ. Хэдийгээр дунд хугацаанд нөлөөлөл үзүүлэх боловч төслийн хугацаа дуусахад эргэн нөхөн сэргээгдэх боломжтой.

Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл: Замын хөдөлгөөн, хөрс хуулалт, тээвэрлэлтээс үүдэлтэй агаарын тоосжилт, дизель түлшээр ажилладаг машин механизм тоног төхөөрөмжөөс гарах хий утаа, дуу чимээ, хог хаягдлаас үүсэх үнэр зэрэг болно.

Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл: Уурхайн зам усалгаа болон унд-ахуйн усны хэрэгцээг гүний худгаас авч ашиглах бөгөөд энэ нь газрын доорх усны хомсдолд үүсгэж болзошгүй.

Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөлөл: Шатах тослох материал болон бүтээгдэхүүн тээвэрлэлтээс шалтгаалсан техникийн олон салаа зам үүсч тоос шороо ихээр дэгдэж агаар, орчны хөрс ургамлыг бохирдуулах хөрсний гадаргад хуурай тоос шороон хучаас үүсгэх.

Машин техникийн олон салаа зам үүсч талбайн ургамлыг сүйтгэж, хөрсийг халцалж, газрыг элэгдэл эвдрэлд оруулан, тоос шороо ихээр дэгдэж агаар, орчны хөрс ургамлыг бохирдуулна. Хүн амын суурьшил нягтарснаас хөрсний элэгдэл эвдрэл, бохирдол үүснэ. Хүнд даацын машин механизм, түүний тээвэрлэлт, засвар үйлчилгээний улмаас шатах, тослох материал, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж хөрс бохирдуулж болзошгүй.

Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл: Ил уурхайн талбайд байсан ургамал устана. Уурхайд олон янзын зориулалтаар машин техник ашиглаж, тэдгээрээс үүдэн олон салаа зам үүсч бий болох магадлалтай. Олон салаа зам үүссэнтэй холбоотойгоор газрын гадаргад шороо тоос үүсч, улмаар салхи шуурганд хийсэн ойр орчмын ургамал бүрхэвч, төслийн талбай тоос шороонд дарагдаж болзошгүй. Байгууламжууд баригдах талбай нь төслийн хугацаанд хүний хөлөөр болон тээврийн хэрэгслээр талхлагдаж бүрэн өөрчлөлтөнд орно. Тосгоноос ахуйн хог хаягдал их хэмжээгээр үүсч, хадгалах зайлуулах стандарт, дүрэм, журам барьж ажиллаагүйгээс гадаргад бохирдол үүсч болзошгүй. Хогийн цэг байгуулах талбайд төслийн хугацааны явцад засвар үйлчилгээний төв болон ажилчдын тосгоноос гарсан хог хаягдал үүссэнээр газрын гадарга болон ургамлан нөмрөгт бохирдол

үүснэ. Тоосжилт үүссэнээс ойр орчмын ургамлууд дээр бууж, үүнээс шалтгаалан навч гэрлийг шингээх нь буурч ургамлын фотосинтезийн бүтээмж доройтох болно.

Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөлөл: Олборлолт явуулсны улмаас хөрс хуулж овоолго хийгээд орхисон байгаа ба овоолго болон түүний орчмын талбайн амьтан /элдэв шавжийн бүлгэмдэл/, тэдгээрийн амьдрах орчин үгүй болох.

Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл: Ажилчдын байрны эрүүл ахуй, хөдөлмөрийн нөхцлийг шаардлагын хэмжээнд байлгаж чадсанаар ажиллагсдын мэргэжлээс шалтгаалах өвчлөл, хөдөлмөрийн чадвараа түр алдалт, үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлж чадна. Уурхайн ажлын үед ажиллах хүнд машин механизмын дуу чимээ, тоосжилт ихэссэнээс хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй.

Болзошгүй осол аваар, саатал, техник, технологийн шугам сүлжээний гэмтэл, гал усны гэнэтийн аюул учирч болзошгүй. Үйл ажиллагааны явцдаа техникийн аюулгүй байдал алдагдах, гэнэтийн осол гарснаас ажилчдын эрүүл мэнд, амь нас эрсдэх аюул үүснэ.

БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

5.1.Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

| № | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Хэрэгжүүлсэн арга хэмжээ | Зардал, 2024 он /төгрөг / |
|----------------------|---|--|------------------------------|
| Агаарын чанар | | | |
| 1 | Уурхайн тээвэрлэлтийн зам, уурхай орчимд тоосжилт дарах усалгааг тогтмол хийх | Усалгааг 4,5,6 саруудад 7 хоногт 1 удаа хийсэн. Өөрийн лицензийн талбайд байрлах олборлолтоос үүссэн усан сангаас усаа авч автоцистерн машинаар 1 удаа услахдаа 5 тн -ий саваар усалгаа хийдэг. Бусад саруудад бороо хур элбэг байсан тул усалгаа хийгдээгүй. Усалгаа хийж буй зургийг доор орууллаа. | Сард 200,000 Нийт 600,000 |
| 2 | Тээврийн хэрэгсэлийн хөдөлгүүрийн тохиргоо, үйлчилгээг тогтмол байлгах, хөдөлгүүрээс гарах утааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах арга хэмжээ авах | Агаарын бохирдлын төлбөрийг төлсөн. | 42,000 |
| 3 | Жилд нэг удаа хүнд машин механизмуудыг техникийн үзлэгт оруулах, засвар үйлчилгээг тогтмол хийх | Хөдөлгүүрээс гарах утааны хэмжилтийг стандартын шаардлага хангах арга хэмжээнд байлгасан. Нийт 2 дугуйт ачигч, 1 экскаваторыг тогтмол үзлэгт оруулсан. | 23,500 |
| Нийт зардал | | | 865,500 |



Зураг 2. Уурхайд усалгаа хийгдэж байгаа байдал

SmartCar Тээврийн хэрэгслийн цахим нэг цэвэр Нүүр Таны сонрт Уйлчилгээ Таны оролцоо Смарткарын тухай Шалгах Нэвтрэх

Нүүр / Тээврийн хэрэгслийн мэдээлэл

Тээврийн хэрэгсэл

Улсын дугаар: 1212УР
 Загвар: Hyundai Robex 2900LC-7
 Үйлдвэрлэсэн он: 2004

Үндсэн цэс

- Гэрчилгээний мэдээлэл >
- Оношилгооны мэдээлэл >
- Даатгалын мэдээлэл >
- % Татвар, хураамж >**
- Торгууль >
- Өвдрэл, гэмтлийн лавлагаа >
- Хилээр нэвтрэн оржирэх үеийн мэдээлэл [Шинэ](#)
- Ачитл, журамлалт >
- Нийслэлийн зам ашигласны хураамж [Шинэ](#)

Татвар, хураамж

Төлөөгүй **Төлсөн**

| Он | Дэлгэрэнгүй | Нийт дүн | Төлөв |
|------|---|----------|---------------------------|
| 2024 | АТБЭРХТатвар: 14,000 ₮ АБТөлбөр: 9,500 ₮ АЗАТөлбөр: 0 ₮ | 23,500 ₮ | Төлөгдсөн |
| 2023 | АТБЭРХТатвар: 14,000 ₮ АБТөлбөр: 9,500 ₮ АЗАТөлбөр: 0 ₮ | 23,500 ₮ | Төлөгдсөн |
| 2022 | АТБЭРХТатвар: 14,000 ₮ АБТөлбөр: 9,500 ₮ АЗАТөлбөр: 0 ₮ | 23,500 ₮ | Төлөгдсөн |
| 2021 | АТБЭРХТатвар: 14,000 ₮ АБТөлбөр: 9,500 ₮ АЗАТөлбөр: 0 ₮ | 23,500 ₮ | Төлөгдсөн |
| 2020 | АТБЭРХТатвар: 9,129 ₮ АБТөлбөр: 9,500 ₮ АЗАТөлбөр: 0 ₮ | 18,629 ₮ | Төлөгдсөн |

Зураг 3. Тээврийн хэрэгслийг техникийн үзлэгт хамруулсан баримт

The screenshot shows the Smartcar website interface. On the left, there is a green sidebar with the title "Тээврийн хэрэгсэл" (Vehicle) and details: "Улсын дугаар 8015VP", "Загвар Wheel Loader SEM653D", and "Үйлдвэрлэсэн он 2021". Below this is a blue sidebar titled "Үндсэн цэс" (Main menu) with options like "Гэрчилгээний мэдээлэл", "Оношилгооны мэдээлэл", "Даатгалын мэдээлэл", "% Татвар, хураамж", "Торгууль", and "Эвдрэл, гэмтлийн лавлагаа". The main content area is titled "Татвар, хураамж" (Taxes and Fees) and has two buttons: "Төлөөгүй" (Not paid) and "Төлсөн" (Paid). A table displays payment records for the years 2022, 2023, and 2024. Each row shows the year, a table of tax types and amounts (ATBӨЯХТатвар, АБТөлбөр, АЗАТөлбөр), the total amount, and a "Төлөгдсөн" (Paid) status.

| Он | Дэлгэрэнгүй | Нийт дүн | Төлөв |
|------|---|----------|-----------|
| 2024 | АТБӨЯХТатвар: 14,000 ₮ АБТөлбөр: 9,500 ₮ АЗАТөлбөр: 0 ₮ | 23,500 ₮ | Төлөгдсөн |
| 2023 | АТБӨЯХТатвар: 14,000 ₮ АБТөлбөр: 9,500 ₮ АЗАТөлбөр: 0 ₮ | 23,500 ₮ | Төлөгдсөн |
| 2022 | АТБӨЯХТатвар: 14,000 ₮ АБТөлбөр: 9,500 ₮ АЗАТөлбөр: 0 ₮ | 23,500 ₮ | Төлөгдсөн |

Зураг 4. Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлын төлбөр төлсөн баримт

The screenshot shows the Smartcar website interface for a different vehicle. The green sidebar shows "Улсын дугаар 9713VP", "Загвар SEM 655D", and "Үйлдвэрлэсэн он 2021". The blue sidebar is the same as in Figure 4. The "Татвар, хураамж" section has the same buttons. The table shows payment records for the years 2022 and 2023. The 2022 entry shows a total of 30,000 ₮, and the 2023 entry shows a total of 23,000 ₮. Both are marked as "Төлөгдсөн" (Paid).

| Он | Дэлгэрэнгүй | Нийт дүн | Төлөв |
|------|---|----------|-----------|
| 2022 | АТБӨЯХТатвар: 0 ₮ АБТөлбөр: 0 ₮ АЗАТөлбөр: 30,000 ₮ | 30,000 ₮ | Төлөгдсөн |
| 2023 | АТБӨЯХТатвар: 13,500 ₮ АБТөлбөр: 9,500 ₮ АЗАТөлбөр: 0 ₮ | 23,000 ₮ | Төлөгдсөн |

Зураг 5. Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлын төлбөр төлсөн баримт

Хүснэгт 5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

| № | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Хэрэгжүүлсэн арга хэмжээ | Зардал, 2024 он /төгрөг / |
|-----------------------|--|--|--|
| Хөрсөн бүрхэвч | | | |
| 1 | Уурхайн талбайн эргэн тойронд уурхайн үйл ажиллагаа явагдаж байгааг анхааруулсан тэмдэг тэмдэглэгээ хийх. | Уурхайд тэмдэг тэмдэглэгээг 2023 онд хийсэн. Зургийг орууллаа. | - |
| 2 | Шимт хөрсийг овоолго байдлаар стандартын дагуу хадгалж, нөхөн сэргээлтэнд ашиглах | Шимт хөрс болон хаягдал овоолгыг ашиглан олборлолтоос үүссэн газруудад нөхөн дүүргэлтийн ажил хийж, нөхөн сэргээлтний ажлыг хийж эхэлсэн. | Нөхөн сэргээлтний төлөвлөгөөний биелэлтэнд оруулсан. |
| 3 | Тээврийн хэрэгслийг маршрутын бус замаар явуулахгүй байх, олон салаа зам гаргахгүй байх | Тээвэрлэлтийн замд олон салаа зам гаргаагүй. Уурхайн гадаад тээврийн тэмдэглэгээ тавьсан тээврийн замаар явдаг. Тэмдэглэгээг зургаар орууллаа. | 2023 онд хийгдсэн. |
| 4 | Шатах тослох материалын хадгалалтанд хяналт тавьж ажиллах, шатах тослох материал алдагдсан тохиолдолд цаг тухай бүрт нь саармагжуулах арга хэмжээ авах | ШТМ хөрсөнд алдагдаагүй, алдагдахаас тогтмол сэргийлж ажиллаж байсан. | - |
| Нийт зардал | | | - |



Зураг 6. Уурхайн үйл ажиллагаа явагдаж байгааг анхааруулсан тэмдэг тэмдэглэгээ байршуулсан байдал



Зураг 7. Замын тэмдэг тэмдэглэгээ байршуулсан байдал

Хүснэгт 6. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

| № | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Хэрэгжүүлсэн арга хэмжээ | Зардал, 2024 он /төгрөг / |
|--------------------|---|---|--------------------------------|
| Усан орчин | | | |
| 1 | Ахуйн бохир усыг ил задгай асгахгүй байх. | Ахуйн бохир усыг ил задгай асгаагүй. | - |
| 2 | Ундны усны шинжилгээг тогтмол өгч байх. | Унд ахуйн уснаас усны шинжилгээ авч, усны шинжилгээний лабораторит шинжлүүлсэн. | ОХШХ-ий биелэлтэнд тусгагдсан. |
| 3 | Хиймэл нуурыг бохирдуулахгүй байх, эргэн тойронд хог хаядал хаяхгүй байх. | Хиймэл нуурыг бохирдуулахгүй байх, эргэн тойронд хог хаядал хаяагүй. | - |
| Нийт зардал | | | - |

5.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 7. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

| № | Нөхөн сэргээлтийн зорилт | Хамгаалах арга хэмжээ | Хэрэгжүүлсэн арга хэмжээ | Зардал, 2024 он /төгрөг / |
|-------------|---|-----------------------|---|------------------------------|
| 1 | Овоолго байдлаар хадгалсан шимт хөрсөөр өөрдсийн олборлосон талбайд нөхөн дүүргэлт хийнэ. | | Шимт хөрс болон хаягдал овоолгыг ашиглан олборлолтоос үүссэн газруудад нөхөн дүүргэлтийн ажил хийж, нөхөн сэргээлтийн ажлыг хийж эхэлсэн. | 15,000,000 |
| 2 | Хиймэл нуур үүсгэсний эргэн тойронд хөрс асгаж тохижуулах | | Хиймэл нуурын эргэн тойронд хөрс асгаж, хөрсийг тэгшилж тохижуулсан. | 3,000,000 |
| Нийт | | | | 18,000,000 |



Зураг 8. Шимт хөрс болон хаягдал овоолгыг ашиглан нөхөн сэргээлт хийсэн байдал




Зураг 9. Хиймэл нуурын эргэн тойронд хөрс асгаж, хөрсийг тэгшилж тохижуулсан байдал

5.3.Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

“Сүхжин” ХХК нь дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх газрыг Дорнод аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас санал авсны үндсэн дээр Дорнод аймгийн Баянтүмэн сумын нутагт эвдэгдэж орхигдон ухаш үүссэн талбайд Техникийн нөхөн сэргээлт хийх ажлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэхээр санал, шийдвэрт хүрсэн.

Хүснэгт 8. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

| № | Дүйцүүлэн хамгаалах зорилт | Хамгаалах арга хэмжээ | Хэрэгжүүлсэн арга хэмжээ | Зардал, 2024 он /төгрөг / |
|-------------|---|---|--|---------------------------|
| 1 | Орон нутгаас санал авсны үндсэн дээр Дорнод аймгийн Хэрлэн сумын 5-р багийн нутаг дэвсгэрт шугам ухаж авсны улмаас эвдэрч, эзэнгүй орхигдсон газарт нөхөн сэргээлт хийх ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэх. | 0.075 га газарт 3 м гүнтэй 2,250 м ³ газрыг булж, тэгшилж, техникийн нөхөн сэргээлт хийнэ. | Шугам ухаж авсны улмаас эвдэрч, эзэнгүй орхигдсон 0.075 га газарт 3 м гүнтэй 2,250 м ³ газрыг булж, тэгшилж, техникийн нөхөн сэргээлт хийсэн. | 4,000,000 |
| 2 | 5-р багийн нутагт шугам ухаж авсны улмаас эвдэрч, хоосон орон зай үүсэж орхигдсон газарт техникийн нөхөн сэргээлтийг 3 жилийн хугацаанд гүйцэтгэж байгаа бөгөөд энэхүү ажлыг 2024 онд дуусгаж, орон нутагт хүлээлгэн өгч акт үйлдэнэ. | 3 жилийн хугацаанд нийт 1.25 га газарт бүхий 37,500 м ³ газарт техникийн нөхөн сэргээлт хийсэн | 3 жилийн хугацаанд дүйцүүлэн хамгааллын ажлын хүрээнд нийтдээ 2.3 км урттай, 6900м ² талбай бүхий 17250м ³ эзлэхүүнтэй шороог булж, техникийн нөхөн сэргээлт хийж дууссан. Энхүү ажлыг Дорнод аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газарт хүлээлгэн өгөхөөр хүсэлт өгсөн байгаа болно. | 15,000,000 |
| 3 | 2024 онд тарьсан бургасыг арчлан хамгаалах, услаж тордох. | 200 ш Бургас, 30ш Чацаргана, 20ш Улиас тарьсан. | Өөрийн эзэмшлийн талбайд тарьсан мод бутыг арчилж, тордож, усалгааг тогтмол хийсэн. | 750,000 |
| Нийт | | | | 19,750,000 |



Зураг 10. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ хийгдсэн газар



Зураг 11. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээндий хүрээнд газрыг булж техникийн нөхөн сэргээлт хийсэн байдал



Зураг 12. Мод бут тарьсан байдал



Зураг 13. Модны усалгаа хийгдэж байгаа байдал

5.4.Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Тус ордын ойр орчмын бүсэд иргэд, оршин суугчид, айл өрх, байгууллага байхгүй байна. Иймд нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө тусгагдаагүй болно.

5.5.Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Элс-хайрганы холимгийн ордын талбайд түүх, соёлын дурсгалт зүйлс илрээгүй байна. Хэрэв уурхайн эдэлбэр газарт түүх соёлын дурсгалын зүйлс, археологи, палентлогийн олдвор илэрсэн тохиолдолд нэн даруй дүүрэг, хорооны захиргаанд болон мэргэжлийн байгууллагуудад мэдэгдэж зохих судалгаа, шинжилгээ хийлгэн дүгнэлт гаргуулах шаардлагатай.


5.6.Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Энэ төлөвлөгөөнд батлагдсан аргачлалын дагуу хийсэн байгалийн аюул, гамшгийн үнэлгээгээр тогтоогдсон учирч болзошгүй байгалийн гамшиг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, шаардагдах зардлыг тусгалаа.

Хүснэгт 9. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

| № | Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ | Хэрэгжүүлсэн арга хэмжээ | Зардал, 2024 он /төгрөг / |
|---|--|--|---------------------------|
| 1 | Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянаж ажиллах. | Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг тогтмол хянаж ажилласан. ISO 45001:2018 нэгдсэн менежментийн тогтолцооны дагуу өдөр бүр техникийн шалгах хуудсыг бөглөж 7 хоног бүр шалгаж ажилласан. | Дотоод төлөвлөлтөөр |
| 2 | Гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах, багаж хэрэгслийг сайжруулах | Манай байгууллага нь ISO 9001:2015, ISO 45001:2018 нэгдсэн менежментийн тогтолцоог 2023 онд нэвтрүүлсэн. ISO 45001:2018 стандартын дагуу гал унтраах багаж хэрэгслийг жил бүр шинэчлэн сайжруулан ажиллаж байна. | 1,390,400 |
| 3 | Уурхайн орчимд үерийн уснаас хамгаалах суваг, шуудуу, хамгаалах даланг сайжруулах | Уурхайн орчимд үерийн уснаас хамгаалах суваг, шуудуу, хамгаалах даланг сайжруулсан. | Дотоод төлөвлөлтөөр |
| 4 | Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө батлуулж ажиллах | Уурхайн аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2024 онд батлуулж, хэрэгжүүлэн ажилладаг. | 500,000 |
| 5 | Ажилд гарахын өмнө ажилчдад аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх | Аюулгүй ажиллагааны зааварчилгааг өглөө бүр ажилд гарахын өмнө өгдөг. ISO 9001:2015, ISO 45001:2018 нэгдсэн менежментийн тогтолцооны дагуу мэргэжил | Дотоод төлөвлөлтөөр |

| | | | |
|--------------------|--|---|------------------|
| | | тус бүр дээр мэргэжлийн үнэлгээ хийлгэж аюулгүй ажиллагааны зааварчилгааг бүрэн боловсруулж ажилладаг. | |
| 6 | Ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хэрэгсэлээр бүрэн хангах (өлмийний хамгаалалттай түрийтэй гутал, хамгаалалтын нүдний шил, дуулга, тоосны маск, ажлын бээлий гэх мэт) | Манай байгууллага нь ISO 9001:2015, ISO 45001:2018 нэгдсэн менежментийн тогтолцоог 2023 онд нэвтрүүлсэн. Энэхүү стандартын дагуу нийт ажилчдын хувцас болон нэг бүрийн хамгаалах хэрэгслээр ханган ажилладаг. Нийт 10 ажилтантай. | 5,779,200 |
| Нийт зардал | | | 6,279,200 |



Зураг 14. 2024 оны аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө



Зураг 15. Гал унтраах багаж хэрэгслийг сайжруулсан байгаа нь



Зураг 16. Үерээс хамгаалах далан шуудууг зассан байдал



Зураг 17. Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцсаар хангасан байдал



Зураг 18. Ажилчдад аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч байгаа байдал

Монгол Улсын иргэн та хөдөлмөрлөх аятай нөхцлөөр хангагдах эрхтэй.

| № | Овог нэр | Мэргэжил зэрэг | Он, сар, өдөр | Хийгдэх ажил | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгааны ерөнхий утга, код | Зааварчилгаа авсан хүний гарын үсэг | Зааварчилгаа өгсөн хүний албан тушаал, овог нэр, гарын үсэг |
|----|-----------|----------------|---------------|--|--|-------------------------------------|---|
